



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/387

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- |         |   |
|---------|---|
| Ахлагч  | -Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч            |
| Гишүүд: | -Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;                     |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;                        |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;                 |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга; |
|         | -Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга;                                |
|         | -Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга;   |
|         | -Нийслэлийн Цагдаагийн газрын дарга;  |
|         | -Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;   |
|         | -Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;  |
|         | -Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;   |
|         | -Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга;  |

111020001803

- Нийслэлийн Тээврийн газрын дарга;
  - Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга;
  - Нийслэлийн Боловсролын газрын дарга;
  - Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга;
  - Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
  - Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга;
  - “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨҮГ-ын дарга;
  - “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨҮГ-ын дарга;
  - Баянгол дүүргийн Засаг дарга;
  - Баянзүрх дүүргийн Засаг дарга;
  - Багануур дүүргийн Засаг дарга;
  - Баганхангай дүүргийн Засаг дарга;
  - Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;
  - Сүхбаатар дүүргийн Засаг дарга;
  - Хан-Уул дүүргийн Засаг дарга;
  - Налайх дүүргийн Засаг дарга;
  - Чингэлтэй дүүргийн Засаг дарга.
- Нарийн бичгийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөний төслийг боловсруулан 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД